



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 02 сарын 16 өдөр

Дугаар А/59

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Улсын Их Хурлын 1994 оны 59 дүгээр тогтоолоор баталсан Хот, тосгоны захирагчийн сонгууль явуулах огцруулах тухай журмын 4 дэх заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.5, 4.1, аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлын 2022 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 06 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хатгал тосгоны захирагчийн сонгуулийн үйл ажиллагааны зардалд 9,867,000 (Есөн сая найман зуун жаран долоон мянган) сая төгрөгийг зарцуулсугай.
2. Дээрх хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн данснаас гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (П.Ариунбат) -т зөвшөөрсүгэй.
3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д даалгасугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН